

**МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ**

2023 оны 04 сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.7 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн А-36 дугаар тушаалаар баталсан “Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4.7.7 дахь заалтын “, эсвэл түүнээс бараа, үйлчилгээ худалдан авах” гэснийг хассугай.

2. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн А-36 дугаар тушаалаар баталсан “Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журам”-ын дор дурдсан агуулга бүхий 3.4.5 дахь заалтыг нэмсүгэй:

“3.4.5.Холбогдох этгээдэд дамжуулан зээлдүүлэх, ашиглуулах, эсвэл түүнээс бараа, үйлчилгээ худалдан авахад зориулан гуравдагч этгээдэд зээл олгох, эх үүсвэр, өрийн хэрэгсэл, хөрөнгө оруулалт байршуулах, баталгаа, батлан даалт, аккредитив болон бусад хүлээж болзошгүй үүрэг гаргах.”

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Ц.Нарандалай), Дотоод аудитын газар (А.Шижирмаа)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ЛХАГВАСҮРЭН